

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

ДОТООД АЛБАН БИЧИГ

№ 03/88

Огноо.2022.06.03

Хаанаас: Захиргаа, удирдлагын газар

Хаана: Виз зөвшөөрлийн газар, Зөрчил шалган
шийдвэрлэх газар, Орон нутаг дахь нэгжүүдэд

Утга: Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах БНСУ-ын иргэдийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл визийн шаардлагаас чөлөөлөх тухай Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоол болон Гадаад харилцааны яамны 10/2609 тоот албан бичгийг хавсралтаар хүргүүлж байна.

Дурдсан хугацаанд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана уу.

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.ДАВААНЯМ





**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.05.27 № 72996

танай _____-ны № _____-т

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР
ТАНАА**

Монгол Улсад 90 хүртэлх хоногийн хугацаагаар ирэх Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсөн Засгийн газрын шийдвэрийн хуулбарыг, Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн албан бичгийн хамт хавсралтаар хүргүүлэв.

Хүлээн авч танилцан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана уу.

Хавсралт 4 хуудастай

**БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА**

Э.ЭНХТУЯА



9131817

9022010516

151613098

A5 Файл.2022

*Among.
23.5, 23.6.2022,
Дон нутаг дахь
нэгдсэн хурал.
Монгол улсын
санхүүгийн
сүлжээний
А5 Файл.2022*

103



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ**

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn,
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2022.05.23 № 10/2609
танай _____-ны № _____-т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА П.САЙНЗОРИГ,
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД НАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 178 дугаар тогтоолоор Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаатай аялал жуулчлалын зорилгоор зорчих Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд визээс чөлөөлөх шийдвэрийг гаргасан.

Уг шийдвэрийг тус яамнаас солонгосын талд болон Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагад дипломат шугамаар мэдэгдээд байна.

Иймд, дээрх шийдвэрийг тогтоолд заасан хугацаанд хэрэгжүүлж ажиллах талаар өөрийн харьяа байгууллагуудад мэдээлэхийг хүсье.

Хавсралт: Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоолын хуулбар
БНСУ-ын Гадаад хэргийн яаманд илгээсэн ноот бичгийн хуулбар

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Д.АНХБАЯР

116221143



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 178

Улаанбаатар
хот

Визийн шаардлагаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.4, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 1.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсүгэй.
2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай.
3. Энэ тогтоолыг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Гадаад харилцааны сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.БАТЦЭЦЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэлд:

"I.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсад жуулчлах зорилгоор ирэх Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Аялал жуулчлалын салбарыг дэмжих, жуулчдыг татах зорилтын хүрээнд Монгол Улсад жуулчлах зорилгоор ирэх Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов.

2. Тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар БНСУ-ын талтай үргэлжлүүлэн ажиллаж, 2012 онд байгуулсан "Виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



MONGOLIA
MINISTRY OF FOREIGN AFFAIRS

К/22-517

Монгол Улсын Гадаад харилцааны яам Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад хэргийн яаманд хүндэтгэлээ илэрхийлэхийн ялдамд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаас Монгол Улсад аялал жуулчлалын зорилгоор ирэх Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг 90 хүртэл хоногийн хугацаанд визгүй зорчуулах шийдвэр гаргасныг үүгээр мэдэгдэх завшаан тохиолдов.

Энэхүү шийдвэр нь 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хүчин төгөлдөр хэрэгжих бөгөөд аялал жуулчлалын зорилгоос бусад зорилгоор (хөдөлмөр эрхлэх, суралцах, урт хугацаагаар оршин суух, хувийн бусад зорилгоор зорчих зэрэг) ирэх иргэд зохих ангиллын визийг урьдчилан авч Монгол Улсын хилээр нэвтрэх болохыг мэдээлж байна.

Энэхүү завшааныг ашиглан Монгол Улсын Гадаад харилцааны яам Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад хэргийн яаманд нэн өндөр хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

Удаанбаатар хот
2022 оны 5 дугаар сарын 16-ны өдөр



БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН ЯАМАНД
Сөүл